

## **ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 23-ны өдөр

№ 20/37

Улаанбаатар хот

### **Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.4 болон 49.5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. “ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт 2-оор баталсугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Төлөөлөн Удирдах Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.





“ЛэндМН ББСБ” ХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
ээлжит хурлын 20/37 тоот тогтоодын Хавсралт 1

<b>КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ</b>	
1. Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 10 (арав) хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
2. Дараалсан 30 хоногийн хугацаанд эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 25 хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
3. Хувьцааг эргүүлэн худалдан авах захиалгийн дээд үнэ	Өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
4. Багц арилжааны худалдан авах ханшийн дээд хязгаар	Нийлбэр дүнгээрээ 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцааг эргүүлэн худалдаж авах багц арилжааны хэлцлийн нэгж хувьцааны ханш нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа	2020 оны 12 сарын 24-ний өдрөөс 2021 оны 03 сарын 31-ний өдрийг дуустал.
6. Мэдээлэл түгээх	Долоо хоног тутмын баасан гарагт тухайн долоо хоногт халаасалсан хувьцааны тоо, дундаж ханшийн талаарх мэдээллийг Компанийн <a href="http://www.lend.mn">www.lend.mn</a> болон Хөрөнгийн биржийн <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
ээлжит хурлын 20/37 тоот тогтоолын Хавсралт 2

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ ЖУРАМ**

### **1. Нийтлэг Үндэслэл**

1.1. Энэхүү журмаар “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн гаргасан нийт энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

### **2. Холбогдох хууль тогтоомж**

2.1. Энэхүү журам нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, ЛэндМН ББСБ ХК-ийн дүрэм, “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Монголын Хөрөнгийн биржийн Арилжааны журам”, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

2.2. Энэхүү журам нь хууль, эрх зүйн хэм хэмжээний акттай зөрчилдсөн тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг баримтална.

### **3. Үйлчлэх хүрээ**

3.1. Энэхүү журам нь Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч АНД Системс ХХК-ийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах харилцаанд энэхүү журам хамаарахгүй.

### **4. Хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл**

4.1. Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хувиас буюу 40,000,000 (дөчин сая) ширхэг хувьцаанаас хэтрэхгүй.

4.2. Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр гүйцэтгэнэ.

4.3. Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:

4.3.1. Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны дээд үнэ нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй;

4.3.2. 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны хэлцлийн ханш нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.

- 4.3.3. Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 10 (арав) хувиас хэтрэхгүй. Энэхүү журам нь дээрх 4.3.2 дахь хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй;
- 4.3.4. Дараалсан 30 хоногийн хугацаанд эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 25 (хорин тав) хувиас хэтрэхгүй. Энэхүү журам нь дээрх 4.3.2 дахь хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй;
- 4.3.5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг 2020 оны 12 сарын 23-ны өдрөөс 2021 оны 3 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэнэ.

## **5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд оролцогчийн бүрэн эрх**

- 5.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) дараах бүрэн эрхтэй:
  - 5.1.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 5.1.2. Энэхүү журмын дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах асуудлыг шийдвэрлэх;
  - 5.1.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, асуулт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох.
- 5.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
  - 5.2.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах;
  - 5.2.2. Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлагнах;
  - 5.2.3. Компани нь хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх;
  - 5.2.4. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах;
  - 5.2.5. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээлэх, Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасуулах, Үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүр зохион байгуулах.

## **6. Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 6.1. Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.